

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

### ИЛТГЭХ ХУУДАС

Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан арга хэмжээнүүдийн  
2025 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийсэн тухай тайлан

2025.12.25

Орхон аймаг

#### **НЭГ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО**

Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан 10 арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг зөв мэдээллээр хангах, дараагийн шатны төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

#### **ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ**

Эрүүл мэндийн салбарт хамаарах бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Журам батлах тухай” 43 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 346 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2025 оны 750 дугаар захирамжийг удирдлага болгон Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан арга хэмжээнүүдийн 2025 оны байдлаар гарсан хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, дүгнэлт өгч ажиллалаа.

Тайлант хугацаанд 2 арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 2025 онд дуусгавар болж байгаа тул хэрэгжилт 2022-2025 оны байдлаар нэгтгэгдэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэж, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлэх (2025-2028) төлөвлөгөөний хэрэгжилт-94,6%-тай үнэлэгдэж, албан тоотоор ЭМЯ-нд хүргэгдсэн.

#### **ГУРАВ.ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛААР БАТЛАГДСАН АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ**

##### **1. “Хорт хавдраас сэргийлэх,хянах (2025-2028 он) хөтөлбөрийн хэрэгжилт**

Тус хөтөлбөр нь Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/241 дугаар тушаалаар батлагдсан. Хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох тогтолцоог бүрдүүлэн, иргэдэд хүрэх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилготой.

Аймгийн хэмжээнд тус хөтөлбөрийн 6 зорилтын хүрээнд 21 арга хэмжээний хэрэгжилт гарсан. Нийт 21 арга хэмжээнээс 100%-тай 12, 70%-тай 9 арга хэмжээ байна. Тус хөтөлбөрийн 2025 оны хэрэгжилт-85,5% (Тодорхой үр дүнд хүрсэн) байна.

*Цаашид:*

- Хавдрын хяналтын урт хугацааны хөтөлбөр, Онко урологийн оношилгоо эмчилгээний удирдамж, Хөхний хорт хавдрын удирдамж стандарт шинээр батлагдсан эсэхийг холбогдох албаны мэргэжилтнээс тодруулан, хэрэгжүүлэх
- Сар бүр мэдээллийн хэрэгслээр хавдрын эрт үеийн шинж тэмдэг болон анхдагч хүчин зүйлтэй тэмцэх асуудлаар цуврал интервенцийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах
- Эмнэлэгт суурилсан бүртгэл мэдээллийг хөгжүүлэх, эргэн мэдээллийг сайжруулах
- Хорт хавдрын анхан шатны бүртгэлийн болон тайлангийн маягтын хөтлөлт, мэдээний чанарт үнэлгээ хийж, танилцуулах
- Хорт хавдрын статистик үзүүлэлт, тусламж үйлчилгээний өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж танилцуулах
- Хойд бүсийн Хавдрын оношилгоо эмчилгээний дэд төвийн үйл ажиллагаа, хүртээмжийг сайжруулах, уялдаа холбоо, бүртгэл мэдээллийг нэмэгдүүлэх
- Хүүхдийн хавдар, цусны хавдрын оношилгоо, эмчилгээний чадавхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн төлөвлөгөө, үйл ажиллагааг хэрэгжүүлэх

## **2. “Жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээний (2024-2027 он) төлөвлөгөөний хэрэгжилт**

Тус арга хэмжээ нь Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/111 дугаар тушаалаар батлагдсан. Жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх, хүчирхийлэлд өртсөн хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилготой.

Тайлант хугацаанд нийт 4 зорилтын хүрээнд 28 арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэхэд хэрэгжилт 83,9% (тодорхой үр дүнд хүрсэн) байна. Нийт 28 арга хэмжээнээс 100%-тай 10, 80-70%-тай 19 заалт байна. Цаашид :

- Аймгийн 2025-2027 оны төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэх
- Эрүүл мэндийн үйлчилгээнд үйлчлүүлэгчийн бэртэл, гэмтэл, өвчлөл, сэтгэл санааны байдал, айдас, зан үйлийн өөрчлөлтийн шалтгааныг тогтоох, хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг шалгах, илрүүлэх, энэ чиглэлээр эрүүл мэндийн ажилтныг чадавхжуулах
- Жендерт суурилсан хүчирхийлэл амиа хорлох, архидан согтуурах, мансуурах гэх мэт зуршлын харилцан хамаарлыг судлах, хариу арга хэмжээ авах
- Хүүхэд өсвөр үе, оюутан залуучуудыг хүчирхийлэл, сэтгэцийн эрүүл мэнд, хоол тэжээл, зан үйлийн байдалд тандалт хийх
- Ажлын байран дээрх жендерт суурилсан хүчирхийллийг судлах
- Гэрийн асаргаанд байдаг өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хүчирхийллийн хохирогч болохоос сэргийлэх, эрт илрүүлэхэд сум, өрхийн эрүүл мэндийн төв, багтай хамтран ажиллах

- Бусад арга хэмжээ/ “Сэтгэцийн эрүүл мэнд”, Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх хамгааллын арга хэмжээний төлөвлөгөө/-тэй уялдуулан хэрэгжүүлэх
- 80-70% хэрэгжилттэй 19 заалтын хэрэгжилтийг ханган ажиллахад салбар дундын оролцоог ханган ажиллахад анхаарах

**3. Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээ /2022-2025 он/ -г хэрэгжүүлэх төлөвлөгөөний тайлан**

Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/523 дугаар тушаалаар тус арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан. Нийт 7 зорилтын хүрээнд 44 арга хэмжээний хэрэгжилт 89,7%-тай (Тодорхой үр дүнд хүрсэн) үнэлэгдсэн. Нийт 44 арга хэмжээнээс 100%-тай 33, 70%-тай 11 заалт байна.

Хүснэгт1. Анхаарах арга хэмжээнүүд:

1.2	Халдварт өвчний тандалтын үйл ажиллагаанд бусад салбарын оролцоог нэмэгдүүлэх	Зөвхөн амьсгалын замын эрхтэн тогтолцооны өвчлөл талаар бичигдсэн.
1.3	Халдварт өвчний хэтийн төлөв, хандлагыг тооцож, бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтвортой байдлыг хангах.	ТТӨ-нөөс бусад халдварт өвчний хэтийн төлөв, хандлагыг тооцсон талаар бичигдээгүй.
3,4	Сүрьеэгийн тусламж үйлчилгээ заавар журмын хэрэгжилтийг хангах нэгдсэн төлөвлөгөөг хангаж ажиллах.	Сүрьеэгийн нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилт шалгуурыг 50% гэж тавьсан. Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд: - Бүх хэлбэрийн сүрьеэгийн эмчилгээний амжилтыг хагас жилээр тооцон ажиллаж, 95% - Нян судлалын шинжилгээгээр батлагдсан сүрьеэгийн тохиолдлын хяналт алдагдлыг хагас жил тутам тооцож 3,5% - Сүрьеэгийн хавьтлын үзлэгийн хамралтыг улирал бүр тооцож, 95%-д тус тус хүргэх зорилт тавьсан, гэвч энэ чиглэлээр тайлан бичигдээгүй. ЭМС-ын 2024 оны 1-р сард А/38 дугаар тушаалаар батлагдсан 7 журмын хэрэгжилтийг ханган ажиллах
3.3.2	Эмийн гаж нөлөөг бүртгэх, мэдээлэхэд эмч, мэргэжилтнийг сургах, бүртгэгдсэн гаж нөлөөнд дүн шинжилгээ хийх.	Сургалт 5 хийгдэхээр шалгуурт оруулсан боловч 1 удаагийн сургалт хийгдэж 45 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Бүртгэгдсэн гаж нөлөөнд дүн шинжилгээ хийх
3.5.5	Эмзэг бүлгийн сүрьеэтэй иргэдийг нийгмийн халамж дэмжлэгт хамруулах.	МСТН- ээс зорилтот бүлгийн 6 иргэнд аминдэм болон хүнсний тусламж олгосон. Нийгмийн дэмжлэгт хамрагдсан хувийг 20% гэж шалгуур тавьсан
4.4	Ажлын байранд БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх мэдлэг дээшлүүлэх сургалт явуулах	Ажлын байранд БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх сургалтад 200 хүнийг хамруулахаар шалгуур тавьсан.

		Согтууруулах ундаа худалдан борлуулдаг 10 аж ахуйн нэгжийн 29 ажилтан, Политехник коллежийн 70 оюутныг хамруулсан. ААНБ-ыг хамруулах, эмчтэй байгууллагын эмч нарыг сургаж хамтран сургалт зохион байгуулах
4.5	Үе тэнгийн сургагч багш бэлтгэж залуучууд өсвөр үеийнхэнд БЗДХ, ХДХВ-ийн халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгаа хийх.	МГБССН, УЗХ-той хамтран үе тэнгийн сургагч багш нарыг бэлтгэж, тэднээр дамжуулан үе тэнгийнхэнд сургалт сурталчилгааг эрчимжүүлж, хамтран ажиллах, эргэх холбоотой байх
7.3	Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн тогтвортой байдлыг хангах	Эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдлын менежментийг сайжруулах үйл ажиллагааны тайлан 2024 оны эхний хагас жилээр 60%-тай.
8.2	Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл сургалт, сурталчилгаа зохион байгуулах.	Ялангуяа шалгуур үзүүлэлтийн дагуу эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, мэдлэгийг эргэн сэргээх сургалтуудыг зохион байгуулах

*Цаашид анхаарах:*

- Ялангуяа шалгуур үзүүлэлтийн дагуу эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, мэдлэгийг эргэн сэргээх сургалтуудыг зохион байгуулах
- Үе тэнгийн сургагч багш нарыг бэлтгэж, тэднээр дамжуулан үе тэнгийнхэнд сургалт сурталчилгааг эрчимжүүлж, хамтран ажиллах, эргэх холбоотой байх
- Эмзэг бүлгийн сүрьеэтэй иргэдийг нийгмийн халамж дэмжлэгт хамруулах талаар санал санаачилга гарган ажиллах
- Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Журам шинэчлэн батлах тухай” /Эмийн гаж нөлөөг бүртгэх, мэдээлэх, үнэлэх, тайлагнах журам/ А/67 дугаар шинэчлэгдсэн тушаалыг эмч, эмнэлгийн мэргэжилтэнд таниулах, эмийн гаж нөлөөг бүртгэх, мэдээлэх чиглэлээр эмч, мэргэжилтнийг сургах ажлыг зохион байгуулах
- Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч нарт сүрьеэгийн тандалт, сэргийлэлт, хяналтын чиглэлээр чадавхжуулах сургалт зохион байгуулах, хийгдсэн хяналтын дүнг үндэслэн төлөвлөлт гарган хэрэгжүүлэх
- Ажлын байранд БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх мэдлэг дээшлүүлэх сургалтыг ААНБ-ыг хамруулан зохион байгуулах
- ЭМС-ын 2024 оны 1-р сард А/38 дугаар тушаалаар батлагдсан журмуудын хэрэгжилтийг ханган ажиллах
- Халдварт өвчний тандалтын үйл ажиллагаанд бусад салбарын оролцоог нэмэгдүүлэх

**4. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлэх (2025-2028) төлөвлөгөөний хэрэгжилт**

Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/219 дугаар тушаалаар тус арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан. Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих бодлого эрхзүй,

нийгэм-эдийн засгийн таатай орчинг бэхжүүлж, эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх, эх, хүүхдэд зонхилон тохиолдох сэргийлж болох өвчин эмгэг, түүний хүндрэлийг багасгах замаар эх, хүүхдийн өвлөл, эндэгдлийг тогтвортой бууруулах зорилготой. Нийт 5 зорилтын хүрээнд 43 арга хэмжээний хэрэгжилт 94,6%-тай (тодорхой үр дүнд хүрсэн) үнэлэгдсэн. Нийт 43 арга хэмжээнээс 100%-тай 36, 70%-тай 7 заалт байна.

**Цаашид:**

- “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангахад салбар дундын оролцоог хангах
- “Эх хүүхдэд ээлтэй эрүүл мэндийн байгууллага”-ын болзол журам батлуулан хөдөлгөөн өрнүүлж ажиллах, жил бүр шалгаруулж байх
- Хүүхдийн мэдрэл, хүүхдийн мэдээгүйжүүлэг, хүүхдийн мэс засал, хүүхдийн хэл засалч, хөдөлгөөн засалч, өсвөр үеийн эмчийг бэлтгэх, орон тоогоор ажиллуулах талаар зөвлөмж хүргүүлэх
- Нярайн эрт илрүүлэг болон нярайн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай дутагдалтай байгаа эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн судалгааг гарган төсвийн төсөлд тусгуулах
- Эрт илрүүлгийн хүүхдийн үзлэгээр илэрсэн өвчлөлд дүн шинжилгээ хийж тайлагнах
- Хүүхдийн яаралтай тусламжийн эмнэлзүйн зааврын хэрэгжилтийг хувийн хэвшлийн хүүхдийн клиник, сум, өрхийн эрүүл мэндийн төвд үнэлэх
- Өсвөр үеийнхэнд ээлтэй тусламж үйлчилгээг үзүүлэх чиглэлээр өрхийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах сургалтыг үе шаттай зохион байгуулах
- Өсвөр үеийнхэнд үе тэнгийн зөвлөгч бэлтгэх, хамтран ажиллах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх
- Өсвөр үеийн кабинетыг бүтэц стандартын дагуу ажиллуулах

**5.Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний /2024-2027/ төлөвлөгөөний 2025 оны хэрэгжилтийн тайлан**

Эрүүл мэндийн сайд, Монгол улсын сайд,олимп, нийтийн биеийн тамир,спортын үндэсний хороон дарга, Боловсрол,шинжлэх ухааны сайд,хөдөлмөр,нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/75, А/09, А/73,А/34 дүгээр хамтарсан тушаалаар тус арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан. Нийт 5 зорилтын хүрээнд 18 арга хэмжээний хэрэгжилт 93,5%-тай (тодорхой үр дүнд хүрсэн) үнэлэгдсэн. Нийт 18 арга хэмжээнээс 100%-тай 11, 70%-тай 7 заалт байна.

**Цаашид:**

- Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний /2024-2027/ нэгдсэн төлөвлөгөөг салбар дундын байгууллагуудтай хамтран боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах

- Тамхины хяналтын тухай хууль, тамхины хяналтын суурь конвенцыг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн дотоод журамд “Тамхигүй орчин” бүрдүүлэх, ухуулга нөлөөллийн ажил зохион байгуулах
- Эрүүл зах, эрүүл мэндийг дэмжигч байгууллалаг хөдөлгөөнийг өрнүүлэх
- Зорилтот бүлэгт тохирсон зохистой хоол бэлтгэх богино хугацааны сургалт зохион байгуулах
- Архи, тамхинаас татгалзах сэдлийг дэмжих зөвлөгөө өгөх, сургалт явуулдаг ТББ-ын судалгааг гаргах, хамтарсан төлөвлөлт хийн хэрэгжүүлэх, архи тамхинаас татгалзах сэдлийг дэмжих сургалт, сурталчилгаа, уулзалтыг хамтран ААНБ-д зохион байгуулах
- Хүүхдийн аутизм өвчнийг илрүүлэх сэтгэлзүйн оношилгооны шинэ технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, эмч, мэргэжилтнийг чадавхжуулах
- Бусад арга хэмжээний хэрэгжилттэй уялдуулан хамтран үйл ажиллагааг зохион байгуулах
- Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдсан төсвийг нэгтгэн тайлагнах
- Тайланг хугацаанд нь ирүүлж байх

## **6. “Сэтгэцийн эрүүл мэнд” арга хэмжээний (2024-2027 он) төлөвлөгөөний хэрэгжилт**

Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/148 дугаар тушаалаар тус арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан. Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх, нийгэм, хамт олонд тулгуурласан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг хянах, бэхжүүлэх, хүн амд эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд оршино Нийт 3 зорилтын хүрээнд 25 арга хэмжээний хэрэгжилт 93,6%-тай (Тодорхой үр дүнд хүрсэн) үнэлэгдсэн. Нийт 25 арга хэмжээнээс 70%-тай 8, 100%-тай 17 заалт байна.

### ***Цаашид анхаарах:***

- 8 заалт 70%-тай хэрэгжилттэй заалтуудын хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай.
- Аймгийн хэмжээнд сэтгэл зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын судалгааг гаргаж, хамтран ажиллах
- Ажлын байранд сэтгэцийн эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа зохион байгуулах
- Хүүхдийн байгууллагын орчинд сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх
- Сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах, сэтгэцийн эмгэгийн тухай нийгэм дэх ташаа ойлголт, хандлагыг өөрчлөх ухуулга нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах

- Хүүхэд бүрийн сонирхол, онцлог хэрэгцээнд нь тулгуурлан сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх цахим хуудас, инстаграм, фейсбүүкийг тогтмол ажиллуулах, ажиллуулж буй цахим хуудсыг эрхэлж буй байгууллага, сэтгэл зүйчтэй хамран ажиллах
- Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалахад салбар дундын оролцоог хангаж ажиллах

### **7. “Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээний (2024-2027 он) төлөвлөгөөний хэрэгжилт**

Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/111 дүгээр тушаалаар тус арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан. Нийт 4 зорилтын хүрээнд 27 арга хэмжээний хэрэгжилт 81,1%-тай (эрчимжүүлэх шаардлагатай) үнэлэгдсэн. Нийт 27 арга хэмжээнээс 100%-тай 10, 70%-тай 17 заалт байна.

*Цаашид анхаарах:*

- Аймгийн 2024-2027 оны төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэх
- Эрүүл мэндийн үйлчилгээнд үйлчлүүлэгчийн бэртэл, гэмтэл, өвчлөл, сэтгэл санааны байдал, айдас, зан үйлийн өөрчлөлтийн шалтгааныг тогтоох, хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг шалгах, илрүүлэх, энэ чиглэлээр эрүүл мэндийн ажилтныг чадавхжуулах
- Жендэрт суурилсан хүчирхийлэл амиа хорлох, архидан согтуурах, мансуурах гэх мэт зуршлын харилцан хамаарлыг судлах, хариу арга хэмжээ авах
- Хүүхэд өсвөр үе, оюутан залуучуудыг хүчирхийлэл, сэтгэцийн эрүүл мэнд, хоол тэжээл, зан үйлийн байдалд тандалт хийх
- Ажлын байран дээрх жендэрт суурилсан хүчирхийллийг судлах
- Гэрийн асаргаанд байдаг өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хүчирхийллийн хохирогч болохоос сэргийлэх, эрт илрүүлэхэд сум, өрхийн эрүүл мэндийн төв, багтай хамтран ажиллах
- Бусад арга хэмжээ/ “Сэтгэцийн эрүүл мэнд”, Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх хамгааллын арга хэмжээний төлөвлөгөө/-тэй уялдуулан хэрэгжүүлэх
- 70% хэрэгжилттэй 17 заалтын хэрэгжилтийг ханган ажиллахад анхаарах

### **8. “Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх хамгаалал”-ын арга хэмжээний (2024-2026 он) төлөвлөгөөний хэрэгжилт**

Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/147 дугаар тушаалаар тус арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан. Нийт 4 зорилтын хүрээнд 30 арга хэмжээний хэрэгжилт 82,6 %-тай (тодорхой үр дүнд хүрсэн) үнэлэгдсэн. Нийт 30 арга хэмжээнээс 100%-тай 16, 70%-тай 14 заалт байна.

*Цаашид анхаарах:*

- Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын чиглэлээр мөрдөгдөж буй хууль эрх зүйг сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавих, арга зүйгээр хангах
- Гэрээр хүмүүждэг, эмээ, өвөө дээрээ өсөж буй, асран хамгаалагч нь хөгжлийн бэрхшээлтэй, эцэг эх нь архины хамааралтай, үл хайхрах хүчирхийлэлд өртдөг бага насны хүүхдийг олж илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг баг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран зохион байгуулах
- Өсвөр үеийн кабинетыг ажиллуулах
- Өсвөр насны хүүхэд, залуучуудын сэтгэцийн эрүүл мэнд, амиа хорлоход хүргэж буй хүчин зүйлийг тодорхойлох судалгаа хийх
- Бусад арга хэмжээнүүдтэй уялдуулан үйл ажиллагааг зохион байгуулах
- 70% бүхий хэрэгжилттэй заалтуудын хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай

9. **“Эрүүл шүд” арга хэмжээний төлөвлөгөө /2024-2027/** :2024.01.19-ны ЭМС, БШУСайдын хамтарсан А/27, А/25 дугаар тушаалаар арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан. Нийт 5 зорилтын хүрээнд 16 арга хэмжээний хэрэгжилт 87,5% /Тодорхой үр дүнд хүрсэн/ үнэлэгдсэн. Нийт 16 арга хэмжээнээс 100%-тай 9, 70%-тай 7 заалт байна.

*Цаашид анхаарах:*

- Эрүүл шүд арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө гаргах
- Арга хэмжээний хэрэгжилтийг хангахад салбар дундын уялдааг хангаж ажиллах
- Хүүхдийн байгууллагын шүд угаах орчин бүрдүүлэлт, шүд угааж хэвшсэн эсэхэд үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангах
- Байгууллага, ЕБС-иудад сургагч багш нарыг бэлтгэх
- Аймгийн хэмжээнд шүд цооролтын түвшинг тогтоох

10. **“Эрүүл аюулгүй сургууль” арга хэмжээний төлөвлөгөө**: 2025.02.06-ны ЭМС, БШУС-ын хамтарсан А/53/47 дугаар тушаалаар батлагдсан. 6 зорилтын хүрээнд 19 арга хэмжээний хэрэгжилт 89,8%/Тодорхой үр дүнд хүрсэн/ үнэлэгдсэн. Нийт 19 арга хэмжээнээс 100%-тай 11, 70%-тай 8 заалт байна .

*Цаашид анхаарах:*

- Эрүүл аюулгүй, сургуулийн ээлтэй орчныг бий болгох
- Сургуульд суурилсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, эмч, багш нарыг чадавхжуулах
- Хүүхэд хамгааллын багийн гишүүдийг чадавхжуулах, үнэлгээ хийх, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллах
- Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдыг товлот дархлаажуулалт хамруулах ажлыг зохион байгуулах
- Сургуулийн гадаад дотоод орчны хөрс, аагаа, гэрэлтүүлэг ус ариун цэврийн байгууламжид эрүүл ахуйн тандалт хийх

11. **Сэргээн засах тусламж үйлчилгээг хөгжүүлэх 2025 оны арга хэмжээний төлөвлөгөө**: Сэргээн засах, тусламж үйлчилгээг урт болон богино хугацаагаар, нотолгоонд суурилсан цогц байдлаар үзүүлэх, чанартай аюулгүй, үйлчлүүлэгч төвтэй тусламж, үйлчилгээний зарчмыг баримтлах замаар олон улсын жишигт нийцүүлэн сайжруулж, хөгжүүлэх зорилготой. Тус арга хэмжээний 3 зорилт, 12 арга хэмжээний хэрэгжилт 95,0%/Тодорхой үр дүнд хүрсэн/ үнэлэгдсэн байна.

### **НЭГДСЭН ДҮГНЭЛТ**

1. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний (2025-2028 он) төлөвлөгөөний хэрэгжилт-94,6% (Тодорхой үр дүнд хүрсэн)
2. “Хорт хавдраас сэргийлэх хянах хөтөлбөр” 2025-2028 хэрэгжилт-87,1% (Тодорхой үр дүнд хүрсэн)
3. Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээний (2022-2025 он) төлөвлөгөөний хэрэгжилт-92,5% (Тодорхой үр дүнд хүрсэн)
4. “Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээний (2024-2027 он) төлөвлөгөөний хэрэгжилт-83,9% (Тодорхой үр дүнд хүрсэн)
5. “Сэтгэцийн эрүүл мэнд” арга хэмжээний (2024-2027 он) төлөвлөгөөний хэрэгжилт-93,6% (Тодорхой үр дүнд хүрсэн)
6. Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх хамгаалал”-ын арга хэмжээний (2024-2026 он) төлөвлөгөөний хэрэгжилт-82,6% (Тодорхой үр дүнд хүрсэн)
7. “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт -85,5% (Тодорхой үр дүнд хүрсэн)
8. “Эрүүл аюулгүй сургууль” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт -89,8(Тодорхой үр дүнд хүрсэн)
9. “Эрүүл шүд” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт -87,5%(Тодорхой үр дүнд хүрсэн)
10. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт-93,5%(Тодорхой үр дүнд хүрсэн)
11. Сэргээн засах тусламж үйлчилгээг хөгжүүлэх 2025 оны арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт-95,0% (Тодорхой үр дүнд хүрсэн)

Дээрх 11 арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт (Тодорхой үр дүнд хүрсэн) үнэлэгдсэн бөгөөд 2 арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 2025 онд дуусгавар болж байна.

### **НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ**

1. Хэрэгжилтийг зорилт, шалгуурын дагуу үнэ зөв, 2000 тэмдэгтэд багтаан тайлагнаж хэвших, тухайн ажлын гүйцэтгэл нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй бол түүний шалтгаан, нөхцөлийг тодорхой дурдах
2. Хэрэгжилтийг гаргахдаа эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийг авч бүрэн гүйцэд болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрөөс үйл ажиллагаанд зарцуулсан санхүүжилтийн мөнгөн дүн, үр дүнг тоо баримттай тайлагнах

3. Нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр тандалт, судалгааг хийж, нотолгоонд суурилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх, орон нутгийн болон олон улсын төсөл хөтөлбөрийг татан санхүүжилтийг шийдвэрлүүлэх чиглэлээр анхаарч ажиллах
4. Шалгуур үзүүлэлтийг тодорхой гаргах, суурь үнэлгээг заавал гаргах
5. Иргэн бүрийг урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулах үйл ажиллагаанд 18-аас дээш насны хамрагдвал зохих иргэдийг бүрэн хамруулах, илэрсэн өвчлөлийг хяналтад авч эмчлэн эрүүлжүүлэхэд анхаарах
6. Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэх, иргэд ялангуяа зорилтот бүлэгт чиглэсэн мэдээлэл, сургалт сурталчилгааг салбар дундын оролцоо, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран эрчимжүүлэх
7. Эрүүл мэндийн байгууллагуудын анхан шатны бүртгэлд дэмжлэгт хяналт хийж, хэрэгжилтийг хангах
8. Телемедицин, цахим технологи ашиглах боломжийг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах талаар анхаарах
9. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, сайжруулах төлөвлөлтийг холбогдох мэргэжилтэн бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэх; нотолгоонд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх
10. Гүйцэтгэл тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн, боловсруулалтын шатанд байгаа ажлуудыг анхаарч дахин төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэх
11. 2025 онд Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан арга хэмжээнүүдийн /3/ дунд хугацааны болон тухайн тайлант хугацааны төлөвлөлтийг боловсруулж батлуулан хэрэгжүүлэх
12. Тус арга хэмжээнүүдийг эрүүл мэндийн салбарын хэмжээнд сурталчлах, иргэдийг мэдээллээр хангах

ТАНИЛЦУУЛСАН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ

ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

П.ХИШГЭЭ